

## АЖ АХУЙ НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын зорилт нь боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино.

### 1. “Зорилгод хүрэх байдал”

Юуны өмнө хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасны дагуу Монгол Улсад спортын олон төрлийг хөгжүүлэх, ялангуяа шинэ тутам гарч ирж буй спортыг хөгжүүлэх, технологийн хөгжилд суурилсан оюуны спортыг татварын бодлогоор дэмжих, үүгээр дамжуулан эдийн засаг бизнесийн шинэ бүтцийг болгох гэж үзэж болохоор байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэгт албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй зарим үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлөх зохицуулалттай бөгөөд уг зохицуулалтад спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг хамаардаг.

Харин дээрх заалтад и-спортын үндэсний шигшээ багийн мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг хамаарах агуулгыг нэмэхээр хуулийн төсөл боловсруулсан нь спортын олон төрлийг хөгжүүлэх, ялангуяа шинэ тутам гарч ирж буй спортыг хөгжүүлэх, технологийн хөгжилд суурилсан оюуны спортыг татварын бодлогоор дэмжих хуулийн төслийн зорилгод нийцэж байна.

| Шалгуур үзүүлэлт           | Үнэлэх хэсэг                                                                                                                                                           | Шалгах хэрэгсэл                           | Үнэлэх                                                                                  | Дүгнэх |
|----------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------|--------|
| Зорилгод хүрэх байдал      | и-спортын үндэсний шигшээ багийн мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэгийг ногдуулсан аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасаж хөнгөлөх | Зорилгод дүн шинжилгээ хийх               | Үр нөлөөг үнэлэх                                                                        |        |
| Хүлээн зөвшөөрөгдөх байдал |                                                                                                                                                                        | Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх | Хэрэгжүүлэх этгээдүүд хүлээн зөвшөөрөх, бүтэц зохион байгуулалт тодорхой эсэхийг үнэлэх |        |

|                 |                                       |                                                                                      |                |
|-----------------|---------------------------------------|--------------------------------------------------------------------------------------|----------------|
| Харилцан уялдаа | Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах | Хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн эсэхийг Хавсралт асуултын дагуу шалгах | Дүгнэлт гаргах |
|-----------------|---------------------------------------|--------------------------------------------------------------------------------------|----------------|

## 2. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”

2006 онд баталсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу үзүүлдэг татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь зарим тохиолдолд үр ашиггүй, зорилтот бүлэгтээ хүрэхгүй байх эрсдэлтэй байдаг тул татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татвар төлөгч татварын тайлангаа гаргаж, татвараа төлсний дараа буцаан олгодог байх харилцааг 2019 онд баталсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар нэвтрүүлсэн байдаг. Ингэснээр татвар төлөгч илүү хариуцлагатай болох, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр ашиг нэмэгдэх ач холбогдолтой гэж хууль санаачлагч /Засгийн газар/ үзэж байжээ.

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлээр тухайн спортын төрлийн холбооны оролцоотойгоор үндэсний шигшээ багийг бүрдүүлж, зохион байгуулах зохицуулалт үйлчилж байна. Иймд хуульд заасны дагуу бүрдүүлсэн и-спортын үндэсний шигшээ багийн мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн одоо байгаа спортын үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэг нэмж тусгах нь энэ салбарт хөрөнгө оруулах дотоодын аж ахуйн нэгж байгууллагад маркетингийн тогтолцоог хөгжүүлэх, нийгэм, эдийн засагт хувь нэмрээ оруулах таатай боломж бүрдэх эерэг талтай байна.

Нөгөө талаас хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дээрх зохицуулалт нь 2024 оны төвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай хамт батлагдсан. Өөрөөр хэлбэл хуулийн дээрх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын байгууллага бүртгэж хэрэгжүүлж хэвшсэн үйл ажиллагаа байх тул энэ хуулийн хэрэгжүүлэх этгээд тодорхой байна.

Түүнчлэн Үндэсний шигшээ баг нь биеийн тамир, спортын тухай хуулийн дагуу тухайн мэргэжлийн холбоотой гэрээ байгуулан ажилладаг бөгөөд ийнхүү төрийн байгууллагууд Биеийн тамир, спортын тухай хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, холбогдох журмаар зохицуулна.

Иймд тус хуулийг хэрэгжүүлэх этгээд татварын байгууллага, тухайн спортын холбоо, биеийн тамир спортын хороо, тухайн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж байх нь тодорхой байна.

3. Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах хэрэгслийн хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтоов:

- хуулийн төслийн зохицуулалт тухайн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зорилттой нийцэж байх бөгөөд хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн болно.
- хуулийн төсөлд тодорхойлсон “и-спортын үндэсний шигшээ багийн мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг” гэх агуулгаар тусгажээ. Харин “и-спорт” нь электрон спорт гэсэн агуулгыг ойлгоно гэсэн зохицуулалтыг хамтад тусгах, шаардлагатай бол тайлбар хэсэгт тусгах боломжтой байна.
- хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа болно;
- хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан зохицуулалт байхгүй болно;
- хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хуулиудад тус тус тодорхой заасан болно;
- хуулийн төсөлд орхигдуулсан зохицуулалт байхгүй болно;
- хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зохицуулалт байхгүй;
- төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжгүй гэдэг нь тандан судалгаагаар тогтоогдсон;
- татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зохицуулалт байхгүй. Татварын ерөнхий хуульд заасны дагуу татварын хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг зөвхөн хуулиар тогтооох зарчмын дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.;
- тухайн хуулийн төсөлд тусгасан зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт байхгүй;
- Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгаагүй;
- хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хөндсөн зохицуулалт байхгүй;
- хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй, олимпын төрөлд хамаарах бүх спортын дэмжлэг хүчин төгөлдөр зохицуулалтад хамаарч байх тул шинэ тутам гарч ирж байгаа төрөл

тул тусгайлан хамааруулахаар нэрлэж тусгасан нь бусад спортын төрөлд болон бусад ямар нэгэн шударга бус өрсөлдөөн гэж үзэх боломжгүй ;

- хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй;
- хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгах шаардлагагүй.
- Тухайн хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс санал авч, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой.

## ДҮГНЭЛТ

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэгт албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй зарим үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлөх зохицуулалттай бөгөөд уг зохицуулалтад спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг хамаардаг.

Харин дээрх заалтад и-спортын үндэсний шигшээ багийн мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг хамаарах агуулгыг нэмэхээр хуулийн төсөл боловсруулсан нь спортын олон төрлийг хөгжүүлэх, ялангуяа шинэ тутам гарч ирж буй спортыг хөгжүүлэх, технологийн хөгжилд суурилсан оюуны спортыг татварын бодлогоор дэмжих хуулийн төслийн зорилгод нийцэж байна.

Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн зохицуулалт байхгүй байна. Харин хуулийн төсөлд “и спорт” гэсэн нэр томъёо хэрэглэсэн байх бөгөөд энэ нь электрон спорт гэх агуулгатай, Биеийн тамир, спортын тухай хуулиар тодорхойлсон “спорт” гэх ойлголтод хамаарч байгаа талаар тодорхой тусгах нь зүйтэй. Ингэснээр хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгод үр дүнтэй хүрэх боломжтой байна.

Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль болон “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан байна гэж үзлээ.